

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хэнтий аймгийн Орон нутгийн судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/42/НА-СТА-ТШЗ**

---

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа  
Утас: 93032714

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

---

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт .....	14
4.3 Албан шаардлага.....	14
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.03.09 № 250

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Орон нутгийн судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Орон нутгийн судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин 1,767.5 мянган төгрөг зарцуулсан, ээлжийн амралтын хоногийн тооцоог хийгээгүйгээс 716.2 мянган төгрөгийн цалин давхардуулан, 466.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй олгосон, 2,779.1 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд дутуу тайлагнасан, 25,028.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, тооцоо хийж баталгаажуулаагүй зэрэг нийт 30,757.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>22,475,391.00</b>	<b>25,637,125.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>608,334.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	<b>608,334.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	<b>608,334.00</b>
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		608,334.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>22,475,391.00</b>	<b>25,028,791.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>22,475,391.00</b>	<b>25,028,791.00</b>
35410	Бичиг хэргийн материал	981,000.00	1,094,400.00
35420	Аж ахуйн материал	21,494,391.00	21,704,391.00
35450	Барилгын засварын материал	-	2,230,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,241,642,885.65</b>	<b>4,437,966,538.09</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,241,642,885.65</b>	<b>4,437,966,538.09</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,063,905,385.65</b>	<b>4,260,229,038.09</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	132,038,472.27	3,344,695,348.27
39202	Хуримтлагдсан элэгдэл	(53,917,539.86)	(68,950,352.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,000,000.00	27,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,900,000.00)	(21,600,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,228,852.00	34,708,852.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,460,525.25)	(28,687,122.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,285,468.00	25,285,468.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,868,590.51)	(18,722,404.27)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	965,561,480.00	965,561,480.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	937,769.00	937,769.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>177,737,500.00</b>	<b>177,737,500.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	177,737,500.00	177,737,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,264,118,276.65</b>	<b>4,463,603,663.09</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>342,660.64</b>	<b>1,142,606.11</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>342,660.64</b>	<b>1,142,606.11</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>342,660.64</b>	<b>1,142,606.11</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	342,660.64	1,142,606.11
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,263,775,616.01</b>	<b>4,462,461,056.98</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,263,775,616.01</b>	<b>4,462,461,056.98</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>279,495,619.00</b>	<b>279,495,619.00</b>
51101	Өмч: - төрийн	279,495,619.00	279,495,619.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>224,016,802.58</b>	<b>3,422,702,243.55</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	224,016,802.58	224,016,802.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,198,685,440.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	760,263,194.43	760,263,194.43
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,264,118,276.65</b>	<b>4,463,603,663.09</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>187,519,100.00</b>	<b>3,421,581,519.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,900,000.00</b>	<b>3,214,726,019.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,900,000.00</b>	<b>3,214,726,019.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,900,000.00	3,214,726,019.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,377,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,900,000.00	3,213,348,719.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>184,619,100.00</b>	<b>206,855,500.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	184,619,100.00	197,627,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	184,619,100.00	197,627,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,228,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,108,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,880,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	240,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>189,053,945.90</b>	<b>222,896,078.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>189,053,945.90</b>	<b>222,896,078.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>187,822,502.17</b>	<b>219,050,686.18</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,090,445.28	139,192,640.68
210101	Үндсэн цалин	93,901,573.01	100,680,528.42
210102	Нэмэгдэл	29,148,570.28	29,554,363.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,040,301.99	8,957,749.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,607,543.63	18,527,783.80
210201	Тэтгэврийн даатгал	10,706,998.32	12,635,411.89
210202	Тэтгэмжийн даатгал	1,382,499.15	1,473,093.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,476,347.93	1,178,474.44
210204	Ажилгүйдлийн даатгал	276,499.22	294,618.57
210205	Эрүүл мэндийн даатгал	2,765,199.01	2,946,185.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,306,877.00	18,211,029.14
210301	Гэрэл, цахилгаан	2,491,961.00	1,564,219.14
210302	Түлш, халаалт	8,499,916.00	16,284,220.00
210303	Цэвэр, бохир ус	315,000.00	362,590.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,393,597.00	11,078,710.00
210401	Бичиг хэрэг	2,984,300.00	3,456,230.00
210402	Тээвэр, шатахуун	4,202,600.00	2,372,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,004,397.00	1,752,880.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	86,500.00	353,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,115,800.00	3,143,700.00
2105	Нормативт зардал	319,800.00	210,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	319,800.00	210,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,296,590.00	5,034,999.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	110,000.00
210604	Урсгал засвар	2,296,590.00	4,924,999.00
2107	Томилолт, зочны зардал	540,000.00	1,881,000.00
210702	Дотоод албан томилолт	540,000.00	1,881,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,943,649.26	24,590,523.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,777,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,943,649.26	21,813,223.56
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,231,443.73</b>	<b>3,845,391.85</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	1,168,996.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,168,996.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,676,395.85
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,676,395.85
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	731,443.73	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	731,443.73	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(1,534,845.90)</b>	<b>3,198,685,440.97</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>127,000.00</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	127,000.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(127,000.00)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(1,661,845.90)</b>	<b>3,198,685,440.97</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>184,619,100.00</b>	<b>208,232,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>1,377,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>1,377,300.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,377,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,377,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>184,619,100.00</b>	<b>206,855,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>184,619,100.00</b>	<b>197,627,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	184,619,100.00	197,627,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>9,228,000.00</b>
131103	ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,108,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,880,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	240,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>184,619,100.00</b>	<b>200,767,166.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>184,619,100.00</b>	<b>200,767,166.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>183,387,656.27</b>	<b>196,921,804.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>137,867,818.35</b>	<b>137,845,835.02</b>
210101	Үндсэн цалин	99,678,946.08	99,333,722.76
210102	Нэмэгдэл	29,148,570.28	29,554,363.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,040,301.99	8,957,749.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,664,896.64</b>	<b>18,382,830.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,764,351.33	12,990,769.59
210202	Тэтгэмжийн даатгал	1,382,499.15	1,348,015.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,476,347.93	1,078,772.30
210204	Ажилгүйдлийн даатгал	276,499.22	269,243.03
210205	Эрүүл мэндийн даатгал	2,765,199.01	2,696,030.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,306,877.00</b>	<b>18,211,029.14</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,491,961.00	1,559,159.14
210302	Түлш, халаалт	8,499,916.00	16,284,220.00
210303	Цэвэр, бохир ус	315,000.00	367,650.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,209,064.28</b>	<b>11,291,110.00</b>
210401	Бичиг хэрэг	2,943,300.00	3,612,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,202,600.00	2,372,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,095,887.00	1,742,280.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	37,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	86,500.00	393,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	880,777.28	3,132,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,749,000.00</b>	<b>210,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,749,000.00	210,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,726,000.00</b>	<b>7,375,999.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	250,000.00
210604	Урсгал засвар	2,726,000.00	7,125,999.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>540,000.00</b>	<b>1,881,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	540,000.00	1,881,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>324,000.00</b>	<b>324,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>1,400,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,400,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,231,443.73</b>	<b>3,845,361.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>1,168,966.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,168,966.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	<b>2,676,395.85</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,676,395.85
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>731,443.73</b>	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	731,443.73	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	-	<b>7,465,634.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>5,480,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>5,480,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>5,480,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	5,480,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-	<b>(5,480,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	<b>1,985,634.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>608,334.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>279,495,619.00</b>	<b>760,263,194.43</b>	<b>224,016,802.58</b>		<b>1,263,775,616.01</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,495,619.00	760,263,194.43	224,016,802.58	-	1,263,775,616.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
<b>C08</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>279,495,619.00</b>	<b>760,263,194.43</b>	<b>224,016,802.58</b>		<b>1,263,775,616.01</b>
<b>D01</b>	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>279,495,619.00</b>	<b>760,263,194.43</b>	<b>224,016,802.58</b>		<b>1,263,775,616.01</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,495,619.00	760,263,194.43	224,016,802.58	-	1,263,775,616.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	3,198,685,440.97		3,198,685,440.97
<b>D09</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>279,495,619.00</b>	<b>760,263,194.43</b>	<b>3,422,702,243.55</b>		<b>4,462,461,056.98</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>197,627,500.00</b>	<b>194,951,104.15</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>197,627,500.00</b>	<b>194,951,104.15</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>197,210,800.00</b>	<b>194,551,104.15</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>138,258,600.00</b>	<b>137,845,835.02</b>
210101	Үндсэн цалин	99,755,100.00	99,333,722.76
210102	Нэмэгдэл	29,431,500.00	29,554,363.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9072000.00	8,957,749.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,665,000.00</b>	<b>18,382,830.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,134,600.00	12,990,769.59
210202	Тэтгэмжийн даатгал	1,382,600.00	1,348,015.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,106,100.00	1,078,772.30
210204	Ажилгүйдлийн даатгал	276,500.00	269,243.03
210205	Эрүүл мэндийн даатгал	2,765,200.00	2,696,030.72
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,607,900.00</b>	<b>18,211,029.14</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,700,000.00	1,559,159.14
210302	Түлш, халаалт	16,414,000.00	16,284,220.00
210303	Цэвэр, бохир ус	493900.00	367650.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,919,400.00</b>	<b>10,599,110.00</b>
210401	Бичиг хэрэг	3,491,000.00	3,488,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,044,400.00	2,044,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,742,280.00
210404	Ном, хэвлэл	250,000.00	37,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	393,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,934,000.00	2,892,700.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>322,600.00</b>	<b>210,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	322,600.00	210,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,376,000.00</b>	<b>7,375,999.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	250,000.00
210604	Урсгал засвар	7,126,000.00	7,125,999.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>360,000.00</b>	<b>225,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	360,000.00	225,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>324,000.00</b>	<b>324,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,377,300.00</b>	<b>1,377,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,377,300.00	1,377,300.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>416,700.00</b>	<b>400,000.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>416,700.00</b>	<b>400,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	416,700.00	400,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>197,627,500.00</b>	<b>194,951,104.15</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>197,627,500.00</b>	<b>194,951,104.15</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	197,627,500.00	194,951,104.15

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,228,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,228,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,228,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>692,000.00</b>
210401	Бичиг хэрэг	124,000.00
210402	Тээвэр, шатахуун	328,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,656,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,656,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,880,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,880,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,228,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,228,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,108,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,880,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	240,000.00

#

#

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Орон нутгийн судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Орон нутгийн судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт нь Хан Хэнтий нутгийнхаа үүсэл хөгжил, түүхэн замнал, үзэсгэлэн төгөлдөр байгаль, эрдэс баялгийн орд, түүх, соёл, зан заншлыг цогцоор нь мэргэжлийн түвшинд дэлгэн олон нийтэд сурталчлах, түүх, соёлын өвийг хадгалан хамгаалж, хүн ардынхаа оюуны хэрэгцээг хангаж нээлттэй үйлчлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орон нутгийн судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 187.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Орон нутгийн судлах музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49.5 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0.6	(0.6)
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	22.5	25.0	(2.6)
Үндсэн хөрөнгө	1,241.6	4,438.0	(3,196.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,264.1</b>	<b>4,463.6</b>	<b>(3,199.5)</b>
Өр төлбөр	0.3	1.1	(0.8)
Засгийн газрын оролцоо	1,263.8	4,462.5	(3,198.7)
Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/	279.5	279.5	-
Өмнөх үеийн үр дүн	224.0	224.0	-
Тайлант үеийн үр дүн	-	3,198.7	(3,198.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	760.3	760.3	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,264.1</b>	<b>4,463.6</b>	<b>(3,199.5)</b>

Мөнгөн хөрөнгө нь 0.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ахмадын сангийн төвлөрүүлэлт байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.6 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,196.3 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн өсөлт нь шинэ барилгыг орлогод бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,462.5 сая төгрөг болж, 3,199.5 сая төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр өссөн.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3,233.0 сая төгрөгөөр буюу 1,724.3 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 35.6 сая төгрөгөөр буюу 18.6 хувиар өссөн нь цалин хөлс, тогтмол зардалтай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 309.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 111.9 сая төгрөгөөр бууруулан 197.6 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс 197.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 197.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 194.9 сая төгрөг зарцуулж, 2.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2.1 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 6.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.4 сая төгрөг нийт 9.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцлох асуудал байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулбал зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар Шилэн дансны тухай хуулийг мөрдөх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлж ажиллах талаар 2 зөвлөмж өгөгдсөн нь бүрэн биелээгүй биелэлт 50 хувьтай байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар бараа материалын тооллого, тооцоо бодолт, анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөрөнгийн дахин үнэлгээний үлдэгдлийг хөрөнгө тус бүрээр авч үзэх болно.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 35.2 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 4.4 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 1.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 29.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн.

#### **4.1 Залруулсан алдаа**

Цалингийн зардлыг тооцооны хүснэгтээр олгосон цалингаас 1.7 сая төгрөгөөр илүү бүртгэснийг залруулсан.

Татварын тооцоо нийлсэн актаас 2.7 сая төгрөгөөр илүү бүртгэснийг залруулав.

#### 4.2 Төлбөрийн акт

Ур чадварын нэмэгдэл олгох тушаал шийдвэргүй 0.5 сая төгрөгийн нэмэгдэл бодож олгосон.

Ээлжийн амралтын хоногийн тооцоо хийгээгүйгээс 0.7 сая төгрөгийн цалин давхардуулан олгосон.

#### 4.3 Албан шаардлага

Шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, нормын хувцас зөөлөн эдлэл, хог хаягдлын зардлаас эдийн засгийн ангиллыг зөрчин 1.8 сая төгрөг зарцуулсан.

Бараа материалын 25.0 сая төгрөгийн үлдэгдлийг тоолоогүй, тооцоо хийж баталгаажуулаагүй.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 2.8 сая төгрөгийн цалинг дутуу тайлагнасан.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Орон нутгийн судлах музей	7	35.2	2	4.4	2	1.2	3	29.6		
<b>ДҮН</b>		<b>7</b>	<b>35.2</b>	<b>2</b>	<b>4.4</b>	<b>2</b>	<b>1.2</b>	<b>3</b>	<b>29.6</b>		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 19/А2370448  
ХАА 2022/42/НАСА ТШС Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Орон нутгийн судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын хоногийн тооцоог хийгээгүйгээс 716.2 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

Энэ нь ЭМ, НХС-ын 2000 оны хамтарсан 166 дугаар тушаалаар батлагдсан "ээлжийн амралт олгох заавар"-ын 13-т "Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Давхардуулан олгосон 716.2 мянган төгрөгийн цалинг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орон нутгийн судлах музейн захирал Н.Нямсүрэн, нягтлан бодогч Д.Гангантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.АРИУНАА  
Д.ОЮУНТУЯА

023050058



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 20/А2370448  
ХТЭ 2022/Н2/НА ТА ТЦБ Чингис хот

Г Төлбөр барагдуулах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Орон нутгийн судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ур чадварын нэмэгдэл олгох тушаал шийдвэргүй 466.3 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэслэлгүй зарцуулсан 466.3 мянган төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 07 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орон нутгийн судлах музейн захирал Н.Нямсүрэн, нягтлан бодогч Д.Гангантуяа нарт хариуцуулав.


ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА



2317144297  
CIOA0046 9074082

023050000



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 164/12370448  
ХЭА 2022/42/НА СТА ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг Орон нутгийн судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, нормын хувцас зөөлөн эдлэл, хог хаягдлын зардлаас эдийн засгийн ангиллыг зөрчин 1.8 сая төгрөг зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Илалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орон нутгийн судлах музейн захирал Н.Нямсүрэн, нягтлан бодогч Д.Гангантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 165/А2370448  
ХТТ 2022/М2/НА СТА ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Орон нутгийн судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 2.8 сая төгрөгийн цалинг дутуу тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орон нутгийн судлах музейн захирал Н.Нямсүрэн, нягтлан бодогч Д.Гангантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 166/АДЗТ0448  
ХДА 2022/42/НА СТА ТУС

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Орон нутгийн судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын 25.0 сая төгрөгийн үлдэгдлийг тоолоогүй, тооцоо хийж баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ.", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө." гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орон нутгийн судлах музейн захирал Н.Нямсүрэн, нягтлан бодогч Д.Гангантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА